



2026 оны Татварын хууль тогтоомжид орсон гол нэмэлт, өөрчлөлтүүд



Татварын шинэчлэлийн хүрээнд Засгийн газраас 2025 оны 12 дугаар сард өргөн мэдүүлсэн татварын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэн 2026 оны 6-р сарын 26-ны өдөр баталсан. Эдгээр өөрчлөлтүүд 2027 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Мөн 2026 оны 7-р сарын 3-ны өдөр батлагдсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг дагалдан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт орж, санхүүгийн байгууллагын гадаад болон дотоодын эх үүсвэрээс татан төвлөрүүлсэн зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 5 хувийн татвар ногдуулах зохицуулалт шинээр тусгагдсан. Энэхүү өөрчлөлт нь Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн үйлчилж байна.

Түүнчлэн, Онцгой албан татварын тухай хуульд 2026 оны 6-р сарын 26 болон 7-р сарын 2-ны өдрүүдэд тус тус оруулсан өөрчлөлтөөр 360 сая төгрөгөөс дээш үнэтэй суудлын автомашинд ногдуулах татварыг нэмэгдүүлж, хуурай янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхины бүтээгдэхүүний татварын суурь болон хувь хэмжээг шинэчилсэн. Эдгээр өөрчлөлтүүд нь холбогдох хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс мөрдөгдөж эхэлсэн.

Энэхүү татварын мэдээллээрээ та бүхэнд татварын хууль тогтоомжид орсон эдгээр нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар товч мэдээллийг танилцуулж байна.



1. Татварын ерөнхий хуульд орсон голлох нэмэлт, өөрчлөлтүүд:

- Татвар төлөгч гааль, татварын хууль тогтоомжийг мөрдөлтийг 100 хүртэлх оноогоор үнэлэх “хууль даган мөрдөлтийн түвшин” үнэлгээний системийг нэвтрүүлнэ. Түвшинг тогтоохдоо татвар төлөгчийн бүртгэл, тайлагнал, татвар ногдуулалт, гаалийн бүрдүүлэлт, төлөлт, гаргасан зөрчлийн мэдээлэл гэх мэт шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэнэ. Хууль даган мөрдөлтийн түвшнийг улирал, жилээр тодорхойлж, татвар төлөгчид татварын нэгдсэн системээр мэдэгдэнэ.
- Маргаан таслах зөвлөл, шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа нөхөн ногдуулалтын актаар ногдуулсан алданги, торгуулийг эцэслэгдэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд татвар төлөгчөөс нэхэмжлэхгүй.
- Татвар төлөгчийн банкн дахь дансыг битүүмжилж, ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар гаргуулах татварын өрийг хэмжээ нь тухайн орлогын 70 хувиас хэтрэхгүй байна. Битүүмжилсэн данснаас ногдол ашиг, харилцан хамаарал бүхий этгээдэд төлөх төлбөрийн болон өөрийн буруутэй үйлдлээс үүсэн өр төлбөртэй холбоотой зарлагын гүйлгээ хийхийг хориглоно.
- Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт тооцох алдангийн нийт дүн нь хугацаандаа төлөөгүй татварын үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхээргүй байна.
- Татвар төлөгч татварын тайланг дараагийн хоёр татварын жилд багтаан залруулж болно.
- Татварын хяналт шалгалтын томилолтыг олгосноос шийдвэр гарах хүртэл хугацаанд төлөөгүй татварт алданги тооцохгүй.

2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын хуульд орсон голлох нэмэлт, өөрчлөлтүүд

- ААНОАТ-ын ачаалалыг бууруулах зорилгоор одоогийн 2 шатлалт хувь хэмжээг дараах байдлаар 3 шатлал хувь хэмжээ болгон өөрчилсөн:

Татвар ногдуулах орлогын жилийн дүн (төгрөг)	Одоогийн хувь хэмжээ	2027 оноос үйлчлэх хувь хэмжээ
6 тэрбум хүртэлх дүнд	10%	10%
6 тэрбумаас давсан 10 тэрбум хүртэлх дүнд	25%	15%
10 тэрбумаас давсан дүнд		25%

Эдийн засгийн эрх чөлөөний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс үйлчлэх өөрчлөлтүүд:

- Монгол Улсын арилжааны банк, санхүүгийн байгууллагын гадаад, дотоодын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 5 хувиар татвар ногдуулах;
- Дотоодын үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2034 онд 90 хувиар, 2035-2040 онд 50 хувиар хөнгөлөх.



2026 оны Татварын хууль тогтоомжид орсон гол нэмэлт, өөрчлөлтүүд

2. ААНОАТ-ын хуульд орсон голлох нэмэлт, өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

- Цаашлаад жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын хөнгөлөлтийн босгыг нэмэгдүүлж, татварын элэгдэлийн зохицуулалтад дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна:

Зохицуулалт	Одоогийн хуулиар	2027 оноос мөрдөгдөх хуулийн өөрчлөлтөөр
ЖДҮ-д олгох татварын хөнгөлөлт (тодорхой салбаруудад үл хамаарна)	Жилийн татвар ногдох орлого нь 1.5 тэрбум төгрөг хүртэл аж ахуйн нэгжүүд ААНОАТ-ын 90 хувийн хөнгөлөлт эдэлнэ.	Жилийн татвар ногдох орлого нь 2.5 тэрбум төгрөг хүртэл аж ахуйн нэгжүүд ААНОАТ-ын 90 хувийн хөнгөлөлт эдэлнэ.
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих татварын хөнгөлөлт	Байхгүй	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг хөнгөлнө.
Элэгдэл, хорогдол тооцох	Байхгүй	Их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах, автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график процессор бүхий сервер, супер компьютерын хувьд 3 жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл хорогдолыг тооцно

- ААНОАТ-ын тайланг тайлагнаж, татвар төлөх хугацааг эцсийн хугацааг сунгасан:

Зохицуулалт	Одоогийн хуулиар	2027 оноос мөрдөгдөх хуулийн өөрчлөлтөөр
Урьдчилан тодорхойлсон хуваарийн дагуу татвар төлөх	- Сар бүр төлөх татвараа 25-ны дотор - Улирал бүр төлөх татвараа тухайн улирал дууссанаас хойшхи сарын 20-ны дотор - Жил бүр төлөх татвараа дараа жилийн 2 сарын 10-ны дотор	- Сар бүр төлөх татвараа сүүлийн өдрөөр - Улирал бүр төлөх татвараа тухайн улирал дууссанаас хойшхи сарын сүүлийн өдрөөр - Жил бүр төлөх татвараа дараа жилийн 3 сарын 5-ны дотор
Татварын албанд ААНОАТ-ын тайланг гаргаж, тайлагнах эцсийн хугацаа	- Хагас жилийн тайлангийн хувьд тухайн жилийн 7 сарын 20-ны дотор, - Жилийн эцсийн тайлангийн хувьд дараа жилийн 2 сарын 10-ны дотор	- Хагас жилийн тайлангийн хувьд тухайн жилийн 8 сарын 5-ны дотор, - Жилийн эцсийн тайлангийн хувьд дараа жилийн 3 сарын 5-ны дотор

3. НӨАТ-ын хуульд оруулах голлох нэмэлт, өөрчлөлтүүд

- Үйл ажиллагааны борлуулалтын орлого нь үргэлжилсэн 12 сарын хугацаанд 50 сая дээш төгрөгт хүрсэн этгээд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх одоогийн босгыг төгрөгийг 400 сая болгож нэмэгдүүлсэн. Сайн дураар НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх босго 10 сая төгрөгийг хэвээр үлдээсэн.
- Хууль даган мөрдөлтийн түвшин “сайн” буюу түүнээс дээш үнэлгээтэй татвар төлөгч хүсэлт гаргасан тохиолдолд татвар төлөх хугацааг эхний удаа 1 сараар хойшлуулах; цаашлаад үнэлгээ буураагүй мөн хойшлуулсан татвараа төлсөний тохиолдолд дараагийн удаа 2 хүртэлх сарын хугацаанд сар бүр тэнцүү төлөлт хийх нөхцөлтэйгээр татварыг хойшлуулж болно. Үүнд импортын бараанд төлөх НӨАТ хамаарна. Хойшлуулан төлөх татварын хэмжээ нь тухайн татвар төлөгчийн сүүлийн улиралд импортолсон ижил төрлийн бараанд төлсөн НӨАТ-ын сарын дунджаас хэтрэхгүй байна.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.



2026 оны Татварын хууль тогтоомжид орсон гол нэмэлт, өөрчлөлтүүд

4. ХХОАТ-ын хуульд оруулах голлох нэмэлт, өөрчлөлтүүд

Зохицуулалтууд	Одоогийн хуулиар	2027 оноос мөрдөгдөх хуулийн өөрчлөлтөөр
Хялбаршуулсан горим	Татвар төлөгчийн хүсэлтээр үйл ажиллагааны орлогод ногдох татварын суурийг нийт дүнгээр тодорхойлж, 1%-аар татвар ногдуулна	Татвар төлөгчийн хүсэлтээр 1 тэрбум төгрөг хүртэлх үйл ажиллагааны орлогод ногдох татварын суурийг нийт дүнгээр тодорхойлж, 1%-аар татвар ногдуулна
Хөнгөлөлт, чөлөөлөлт	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын нийт дүнд 2%-ийн татвар ногдуулна.	Татвар төлөгчийн анх удаа өмчилж, амьдран суусан, улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд баригдаагүй бол орон сууцаа борлуулж олсон орлогыг ХХОАТ-аас чөлөөлнө.
Төлөлт, тайлагнал	Дараа оны 2 сарын 15-ны өдрийн дотор	Дараа оны 3 сарын 5-ны өдрийн дотор

Жилийн цалин хөдөлмөр хөлс болон шууд бус орлогод ногдох татварын хувь хэмжээний шатлалыг дараах байдлаар 2027, 2028 онуудаас өөрчлөгдөх ба уг орлогод эдлүүлдэг татварын хөнгөлөлт 2027 оноос хүчингүй болно:

Татвар ногдуулах жилийн дүн /төгрөгөөр/	Хувь хэмжээ		
	Одоогийн хуулиар	2027 оноос	2028 оноос
0 - 9,504,000	10%	0%	0%
9,504,001 - 24,000,000	10%	10%	1%
24,000,001 - 120,000,000	10%	10%	10%
120,000,001 - 180,000,000	15%	15%	15%
180,000,000 дээш	20%	20%	20%

Эдийн засгийн эрх чөлөөний хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс үйлчлэх өөрчлөлт:

- Дотоодын үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2034 онд 90 хувиар, 2035-2040 онд 50 хувиар хөнгөлөх.

5. Онцгой албан татварын хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд

- Импортлосон суудлын автомашины гаалийн үнийн 360,000,000 төгрөгөөс давсан хэсэгт ногдох татварыг 33%-иар нэмж тооцож, ногдуулах өөрчлөлт 2026 оны 6-р сарын 26-ний өдөр орсон нь хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.
- 2026 оны 7 сарын 2-д орсон нэмэлт өөрчлөлтөөр Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхид ногдуулах татварын суурь болон хувь хэмжээг дараах байдлаар өөрчилсөн:

№	Барааны нэр төрөл	Татварын суурь	Хуучин хувь хэмжээ	Шинэ хувь хэмжээ
1.	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	Биет нэгжид болон Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж борлуулсан үнэ, эсхүл импортын гаалийн үнээс хувиар тооцож хослосон хэлбэрээр татвар ногдуулна.	4,180 төгрөг	30%
2.	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи		3,130 төгрөг	30%
3.	Хамрын тамхи		3,130 төгрөг	20%



2026 оны Татварын хууль тогтоомжид орсон гол нэмэлт, өөрчлөлтүүд

Холбоо барих мэдээлэл:



Абдулхамид Муминов
Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
abdulkhamid.m.muminov@pwc.com



Цэндмаа Чойжамц
Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com



Энхзул Жамбал
Ахлах Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com



Энхсанаа Эрдэнэ-Очир
Ахлах Менежер
Татварын зөвлөх үйлчилгээ
enkhsanaa.erdene-ochir@pwc.com

*Та татварын хууль
тогтоомжид орсон
нэмэлт, өөрчлөлтүүдтэй
холбоотой татварын
зохицуулалтуудын талаар
илүү дэлгэрэнгүй зөвлөгөө
авах, татварын
хөнгөлөлт, чөлөөлөлт
болон бусад
зохицуулалтыг судалж,
хэлэлцэхийг хүсвэл
бидэнтэй холбогдоно уу.*

*Бид танд туслалцаа
үзүүлэхдээ таатай
байх болно.*

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.